



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.04.27, № 19

Асуулга тавих тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д Улсын Их Хурал "...төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах,...Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой..." байх заалтууд тусгагдаж хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн билээ.

Энэ дагуу та бидний санаачилга, хамтын хичээл зүтгэлээр "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсан түүхтэй.

Гэтэл Улсын Их Хурлын даргын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 51 тоот захирамжаар байгуулагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллаж байх хугацаанд яамд болон бүх шатны Засаг дарга тус хуулийг хэрэгжүүлэх асуудлаар ойлголтын зөрүүтэй байсан нь харагдсан. Иймд **"Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай"** Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолын 3 дахь заалтаар энэхүү ойлголтын зөрүүг арилгаж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх тодорхой чиглэлийг Засгийн газарт өгсөн. Гэвч ойлголтын зөрүүтэй байдал одоог хүртэл үргэлжилсээр байна.

Нөгөө талаар, **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т** "Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үндэсний хөгжлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, бусад төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулна." гэж, мөн зүйлийн 18.3-т "Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон дараа жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 5 дугаар сарын 25-нд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ." гэж тус тус заасан.

2020000106

Хуулийн үзэл баримтлалын хувьд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь ирэх оны төсвийн суурь болох бодлогын гол баримт бичиг бөгөөд улсын төсөв жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх ёстой. Нөгөөтэйгүүр Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар 5 тодорхой чиглэл өгсөн билээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Танд хандан тавьж байна. Үүнд;

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан эсэх, боловсруулсан бол урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилго, зорилтын хэдийг нь ямар хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгасан, оролцогчдоос санал авсан байдал, саналыг тусгасан, тусгаагүй үндэслэл болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх явц ямар түвшинд байгаа талаар;

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд боловсруулсан хуулийн төслүүдийг 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын явцын талаар;

3. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дүн шинжилгээ хийж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлж шинэчлэн батлах шаардлагатай хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын явцын талаар, одоо үйлчилж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгээс хэдийг нь хүчингүй болгох, хэдийг нь урт хугацааны бодлогод нийцүүлэн нэгтгэн боловсруулж байгаа талаар;

4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан холбогдох журмыг 2021 оны 3 дугаар сарын дотор баталж, тайлбарлан таниулах ажлын явцын талаар;

5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар салбар болон орон нутгийг нэгдсэн удирдлага, арга зүй болон шаардлагатай системчлэл, загварчлал, аргачлал, гарын авлага, программаар хангах ажлын явцын талаар;

6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах, хариуцсан байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, чиг үүрэг болон тогтолцооны дотоод үйл ажиллагааг хангах хүчин зүйлийг оновчтой тогтоож, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд бүтэц хоорондын хамаарал, төр-хувийн хэвшлийн түншлэлийн

2020000166

харилцааг тодорхойлон, төрийн захиргааны төв байгууллага байгуулах талаарх зураглал гарган, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын явцын талаар.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ

П.АНУЖИН

Б.БАТТӨМӨР

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Х.БУЛГАНТУЯА

Х.ГАНХУЯГ

М.ОЮУНЧИМЭГ

Ч.УНДРАМ

Д.ӨНӨРБОЛОР

2020000166